



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

“Монгол-Хятадын аялал жуулчлалын өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 18.2.1, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 24-ний А/558 дугаар захирамж, тус газрын 2017 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 1.4.1.2, газрын дүрмийн 2.5.3, 3.1.9, 3.1.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хөрш орнуудын аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Цайны замын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох, танилцуулах зорилго бүхий “Монгол-Хятадын аялал жуулчлалын өдөрлөг” арга хэмжээг 2017 оны 07 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулахыг Бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн /Н.Алтанзаяа/-д даалгасугай.

2. “Монгол-Хятадын аялал жуулчлалын өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 18 020 000 /Арван найман сая хорин мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Balto* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 07 сарын 04 өдрийн А/С/ дугаар тушаалын хавсралт



"МОНГОЛ-ХЯТАДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨДӨВЛӨГ"  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА


2017 оны 7 сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот


№	Үйл ажиллагаа	Оролцогчдын тоо	Үргэлжлэх хугацаа	Нэгж үнэ /төгрөгөөр/	Дүн /төгрөгөөр/
1	Нүүдэлчдийн наадам	32 бөх, 16 морь, 4 сур харваач	3 цаг	5.000.000	4.550.000
2	Морьтон баатрын угталт	10 морьтон	30 мин	300.000	300.000
3	Хадаг сүүтэй угталт	2-4 хүн	Гадаадын төлөөлөгч-дийг угтана	150.000	150.000
4	Монгол үндэсний хувцас загварын тоглолт /Торго салон/	2 коллекц	30 минут	2.800.000	4.800.000
5	Урлагийн тоглолт	Урлагийн баг	1 цаг 30 мин	8.000.000	7.270.000
6	"Энхтайван, Найрамдал, Залуу элч" хүүхдийн аяллын нээлтийн арга хэмжээнд зориулсан хоёр орны хүүхдүүдийн урлагийн тоглолт	12	1 цаг 20 мин	500.000	500.000
7	Цайны замын хөшөөний суурь хийх, хөрсийг тэгшлэх	1	-	400.000	400.000
8	Мод суулгахад хэрэглэгдэх хүрз, ёслолын бээлий, ажлын бээлийн, тууз, хайч авах	Тус бүр 9 ш	-	50.000	50.000
<b>НИЙТ</b>					<b>18.020.000</b>

--00000--

ХЯНАСАН:  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

 Б.БАТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:  
ДОТООДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖИЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 Н.АЛТАНЗАЯА